



БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ

2024 оны 02 сарын 23 өдөр

Дугаар 1/01

Улаанбаатар хот

Багахангай дүүргийн 2024 оны Газар
зохион байгуулалтын төлөвлөгөөнд тодотгол
оруулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.17 дахь заалт, 48 дугаар зүйлийн 48.1 дэх хэсэг, Газрын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.2 дахь заалтыг тус тус үндэслэн нийслэлийн Багахангай дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит XXIII хуралдаанаас ТОГТООХ нь:

1. Дүүргийн 2024 оны Газар зохион байгуулалтын төлөвлөгөөний тодотголыг хавсралтаар баталсугай.

2. Дүүргийн 2024 оны Газар зохион байгуулалтын төлөвлөгөөний тодотголыг дүүрэг хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөтэй нягт уялдуулж, биелэлтийг хангах талаар удирдлага, зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллахыг дүүргийн Засаг дарга (А.Сүхболд)-д даалгасугай.

3. Төлөвлөгөөний дагуу иргэн, хуулийн этгээдэд газар эзэмшүүлэх, ашиглуулах ажлыг хууль журмын дагуу зохион байгуулж ажиллахыг дүүргийн Газар зохион байгуулалтын алба (Ч.Магадсайхан)-нд үүрэг болгосугай.

4. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын зөвлөлд даалгасугай.

ДАРГА



Ф.МӨНХГЭРЭЛ



Багахангай дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 92 дугаар сарын 23 ны өдрийн 101 дүгээр тогтоолын хавсралт

ДҮҮРГИЙН 2024 ОНЫ ГАЗАР ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ТОДОТГОЛ

20616001: Төсөвт байгууллагын зайлшгүй хэрэгцээнд олгох газар

№	Сум/Дүүрэг	Баг/Хороо	Төлөвлөлтийн нэгж талбар	Газрын нэр	Газрын зориулалт	Талбайн хэмжээ [m2]	Улирал I- IV
1	Багахангай	1-р хороо	4005500	Ногооны талбайн хойд талд	2505: Биеийн тамирын зориулалттай гадаа талбай, спортын барилга, байгууламж	200000	+

20701001: Хүнд үйлдвэр байгуулах газрын төлөвлөлт

№	Сум/Дүүрэг	Баг/Хороо	Төлөвлөлтийн нэгж талбар	Газрын нэр	Газрын зориулалт	Талбайн хэмжээ [m2]	Улирал I- IV
1	Багахангай	1-р хороо	4005499	Үйлдвэрийн бүсэд	2302: Үйлдвэрлэлийн барилга, байгууламж, бусад газар	10000	+